



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/124

Арвайхээр сум

Батлан хамгаалах бодлого, зорилт,  
Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, хүүхэд залуучууд, өсвөр үеийнхэнд цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх, цэргийн хөдөлмөрийн үнэ цэнэ, цэргийн гэрээт болон хугацаат алба хаахын ач холбогдол, давуу талыг таниулан мэдрүүлэх, Зэвсэгт хүчний анги салбарууд, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулж явуулсугай.

2.Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах арга хэмжээнд шаардагдах 7,437,500 (долоон сая дөрвөн зуун гучин долоон мянга, таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газар дарга (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




А.ИШДОРЖ

6223 11 0204

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 23 дугаар  
сарын 22-ны өдрийн 4124 дугаар  
захирамжийн хавсралт



БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО, ЗОРИЛТ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОРОН НУТАГТ  
СУРТАЛЧЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Зохион байгуулах арга хэмжээ	Хугацаа	Зардлын задаргаа	Нийт зардал (мян.төг)
1	“Өмнөговь” цэргийн хүрээнд хугацаат цэргийн алба хааж байгаа цэрэг дайчидтай “Нэг нутгийн уулзалт өдөрлөг”-ийн арга хэмжээ зохион байгуулах;	03.25-03.28	185x16,500=3.052,500	3.052,500
2	МСҮТ, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд “Миний эх орон, миний бахархал” сэдвээр “ЭСЭЭ” бичлэгийн уралдааныг зохион байгуулж явуулах;	03.06-03.20	I байр 60,000 II байр 40,000 III байр 30,000 Тусгай байр 2x20,000=40,000 Өргөмжлөл 25,000x3=75,000	245,000
3	ЕБС-ийн дунд ангийн сурагчидтай Цэрэг-эх орны сэдвээр “АХА” цэнгээнт нэвтрүүлэг болон аймгийн ЗДТГ, Зэвсэгт хүчний анги, салбар, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын “Сагсан бөмбөг, Гар бөмбөг”-ийн тэмцээний зардал;	03.09-03.11	Өргөмжлөл 25,000x3=75,000 Өргөмжлөл 6x35,000=210,000	285,000
4	“Эх орон танаа” цэргийн дуу дуулаачдын аймгийн уралдааныг зохион байгуулах	03.14	I байр 250 000 II байр 200 000	450,000
5	Аймгийн Засаг даргын нэрэмжит “Арвайхээр” цэргийн хүрээний “Марш тактикийн аварга тасаг” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж явуулах;	03.15-03.16	Өргөмжлөл 3x50,000=150,000 I байр 500,000 II байр 400,000 III байр 300,000 Тусгай байр 150,000 Батламж 70x1500=105,000	1.605,000

6	Аймгийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын төлөөлөл (50-55 хүүхэд)-ийг ЗХ-ний 256 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцуулж, тэдэнтэй уулзалт, ярилцлагын арга хэмжээ зохион байгуулах	03.10	1 удаагийн хоол 55х9100=500,000 ШТМ-ын зардал-150,000 төг (ДТ-38л)	650,000
7	“Арвайхээр цэргийн хүрээ”-ний нэгдсэн тооллогын арга хэмжээний зардал;	03.17	2 хайрцаг-225,000=450,000	450,000
8	Аймгийн удирдлага Зэвсэгт хүчний анги салбар, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын сургалт, семинар;	03.16	30 хүн - 23,300=700,000	700,000
<b>Бүгд</b>			<b>7.437,500</b>	